

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Эрүүгийн хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай хуулийн төсөл*

Монгол Улсын Эрүүгийн хууль дахь гэмт хэргийн тухай ойлголтод “нийгэмд аюултай байдал” гэх ухагдахууныг хэрэглэх замаар эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлд заасан хууль ёсны зарчим буюу гэмт хэргийг зөвхөн хуулиар тодорхойлох зарчим, үзэл санааг гажуудуулан гэмт хэрэг нь эрүүгийн хуульд заасан байхаас гадна нийгэмд аюултай гэх шинжийг агуулах ёстой, гэмт хэргийг нийгмийн аюулын шинж чанараар нь хэмжинэ, эрүүгийн хариуцлагыг гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт нь тохируулан хүлээлгэнэ гэх үзэл сурталжсан, субъектив агуулга, хэмжүүр хуульчилагджээ.

Эрүүгийн хуулийн хууль ёсны зарчим нь гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял, албадлагыг зөвхөн хуулиар тодорхойлох ёстой гэсэн агуулгыг илэрхийлдэг. Ингэснээр хэн нэгэн эрх мэдэлтэн өөрийн үзэмжээр бусдыг буруутгаж эрүүгийн ял, албадлага хэрэглэх дур зоргыг хязгаарладаг. Гэтэл Эрүүгийн хуульд хэн нэгний үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, ял, албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ “нийгэмд аюултай” гэх субъектив ойлголтыг нэмж хуульчилсанаар шүүх үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, ял, албадлагын арга хэмжээ оногдуулж хүлээлгэхдээ “нийгмийн аюул” гэх хийсвэр ойлголт хэрэглэж “гэмт хэрэгт тооцох, ял оногдуулах эсэхийг зөвхөн хуулиар тодорхойлно” гэсэн эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмыг гажуудуулж шүүгч, прокурор, өмгөөлөгч өөрийн санаагаар томъёолох “нийгэмд аюултай, нийгэмд аюулгүй” гэсэн субъектив шалгуураар гэмт хэрэг, түүнд хүлээлгэх ял албадлагын арга хэмжээг тодорхойлж үнэлэх боломжтой болжээ.

Эрүүгийн хуулийн энэхүү хууль ёсны зарчмыг хийсвэр шалгууртай болгосоныг шүүх хэрэглэж гэмт хэрэгт тооцох, оногдуулах ялын төрөл, хэмжээг тогтооход удирдлага болгож байгаа нь судалгаагаар тогтоогдов.

Түүнчлэн Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.6 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх ял, албадлагын арга хэмжээг хүндрүүлэх нөхцөл байдлыг тодорхой зааж, энэ зүйлд заагаагүй нөхцөл байдлыг харгалзан ял, албадлагын арга хэмжээг хүндрүүлэхийг хориглосон. Гэтэл шүүх шийдвэртээ хэргийг нийгэмд аюултай учраас, нийгмийн хор аюул бага учраас хэмээн ял, албадлагын арга хэмжээг тогтоож байгаа нь эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмыг үгүйсгэж буй бас нэг хэлбэр юм.

Иймд Монгол Улсын Эрүүгийн хуулийн нийгэмд аюултай байдал, нийгмийн аюулын шинж чанар гэсэн ойлголтыг хасахаар тусгана. Ингэснээр шүүхийн практикт хэвшил болоод буй нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, нийгэмд аюултай байдал гэх субъектив үнэлэмжийг ашиглаж шүүх гэмт хэрэг мөн эсэхийг тодорхойлох, ял, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тодорхойлохдоо ашиглахыг зогсоох нь зүйтэй байна.

Хуулийн төсөлд “Эрүүгийн хуулийн 1 дүгээр бүлгийн 1.3.3, 1.3.4, 1.4.1, 1.4.2, 1.4.4, 1.5.1, 1.5.2, 1.5.3, 1.5.4, 1.6.1, 1.6.3, 1.6.4, 1.6.5, 1.10.6, 2 дугаар бүлгийн 2.7.2, 2.7.3, 2.8.3, 2.8.4, 5 дугаар бүлгийн 5.1.1, 5.1.3, 5.1.4, 5.1.5, 6 дугаар бүлгийн 6, 6.1, 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.2, 6.2.1, 6.2.2, 6.3.1, 6.4.1, 6.5.1, 6.7.1, 6.7.1.1, 6.15.1, 8 дугаар бүлгийн 8, 8.1, 8.1.1, 8.1.2, 9 дүгээр бүлгийн 9, 9.1, 9.1.3, 9.1.4, 9.7, 9.7.1, 9.7.2, 9.7.3, 9.7.4-д “эрүүгийн хариуцлага” гэснийг “ял, албадлагын арга хэмжээ” гэж, 6.7.1-д “эсхүл эрүүгийн хариуцлагаас” гэснийг “эсхүл ялаас” гэж, 4 дүгээр бүлгийн 4.1.4, 7 дугаар бүлгийн 7.4.4, 7.5.3, 13 дугаар бүлгийн 13.4.1, 21 дүгээр бүлгийн 21, 21.1 дүгээр зүйлийн 21.1.1, 21.6.1, 21.9.3, 21.14.1, 21.14.2-т “хэрэг шалган шийдвэрлэх” гэснийг “хэрэг хянан шийдвэрлэх” гэж өөрчлөхөөр” тусгана.

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хэмээх нэр томъёог хэрэглэж улмаар бусад хуулиар энэхүү эрүүгийн хариуцлага хэмээх ухагдахууныг үндэслэл болгож нийгмийн харилцааг зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “шударга ёсны” зарчим, түүнийг Эрүүгийн хуульд “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэснийг зөрчихөд хүргэсэн байна. Эрүүгийн хууль дахь эрүүгийн хариуцлага гэсэн ухагдахуунд “ял, албадлагын арга хэмжээ” гэсэн хоёр өөр агуулга, эрх зүйн үр дагавар бүхий ойлголт хамаардаг. Гэтэл уг хоёр ойлголтыг нэгтгэж эрүүгийн хариуцлага хэмээн томъёолсоныг эрүүгийн эрх зүйн бус нийгмийн харилцааг зохицуулсан хуульд шууд иш татан хэрэглэж ял шийтгүүлээгүй, шүүх ял шийтгэх шаардлагагүй, хэдийгээр гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй боловч түүний улмаас үүссэн үр дагавар нь ялимгүйн улмаас шүүх ял оногдуулахгүй эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ хэрэглэсэнийг хамааруулсан нь хүний эрхийг дордуулахад хүргэжээ. Иймд эрүүгийн хариуцлага гэх ойлголтыг нарийвчлан ял, албадлагын арга хэмжээ хэмээн зааглаж бусад хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үзүүлж эрх зүйн үр дагаварыг зөвхөн эрүүгийн ял хэмээх ойлголтод хамааруулж хэрэглэх хууль зүйн практик тогтоох шаардлагатай болжээ.

Энэхүү төслөөр “Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 1.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг өөрчлөн найруулж, 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “нийгэмд аюултай” гэснийг хасаж, 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцож” тусгана.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн “13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах” зүйлийг шүүхийн практикт хэрэглэх явцад иргэн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл төрийн байгууллага, албан тушаалтаны үйл ажиллагааны талаар шүүмжлэл, хардлага, эргэлзээгээ илэрхийлж мэдээлэл түгээснийг “хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан” хэмээн эрүүгийн хэрэг үүсгэх, ял оногдуулах буруу жишиг тогтжээ. Төрийн байгууллага, албан тушаалтаныг хуулийн этгээд гэж үзэх нь хууль бус юм. Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлд “25.1. Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” хэмээн заасан. Мөн хуулийн 7 дугаар зүйлд “7.3.Төр, засаг захиргаа,

нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, нийслэл, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно” гэж заасан. Үүнээс үзвэл төрийн байгууллага албан тушаалтан тухайлан хуулийн этгээдийн статусгүй бөгөөд хэрэв хуулийн этгээд зүгээс эрх зүйн харилцаанд оролцвол “Монгол Улсын төр” гэсэн нэг эрх зүйн этгээд л байх боломжтой. Гэтэл эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хохирогчоор аль нэг төрийн байгууллагыг тогтоож буй нь эрүүгийн хуулийн тодорхойгүй байдалтай холбоотой байна. Иймд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд заасан “хуулийн этгээд” гэх нэр томъёоны талаар хуульчилсан тайлбар хийх нь зүйтэй гэж үзэв.

Төслөөр -“Энэ зүйлд заасан “хуулийн этгээд” гэдэгт төрийн байгууллага хамаарахгүй” гэсэн тайлбар нэмнэ.

Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл батлагдсанаар шүүх нийгэмд аюултай байдал, нийгмийн аюул гэх субъектив үнэлэмжийг ашиглан гэмт хэргийг үнэлж, ялын төрөл, хэмжээг тогтоож хууль дээдлэх зарчмыг гажуудуулж буй байдлыг зогсооно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын иргэн “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”. Мөн “... задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасныг үндэс болговол гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хувь хүн хуулиар тусгайлан нууцад тооцож хамгаалахаар зааснаас бусад мэдээ, баримтыг олж мэдэх, хүлээн авах эрхтэй, хүний эрх, нэр төр, алдар хүнд, нийтийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төрийн нууцыг хуулиар тогтоож хамгаалах ёстой байна.

Гэтэл Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг олж мэдсэн хүн мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг задруулсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь ямар нэгэн хуулиар нууцлаагүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх баримт сэлтийг “мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээлэл” гэсэн өргөн хүрээг хамруулан томъёолж Монгол Улсын Үндсэн хуулиар иргэнд олгосон эрх, эрх чөлөөг үндэслэлгүйгээр хязгаарласан явдал болжээ. Мөн албаны нууцыг хадгалах, хамгаалах этгээдэд оногдуулах хариуцлагыг үүрэг хүлээгээгүй этгээдэд халдаан хэрэглэж буй нь шударга ёсыг гажуудуулахад хүргэжээ.

Иймд Монгол Улсын Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлд заасан мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн дараах байдлаар өөрчлөх шаардлагатай байна.

1. Хуулийн төсөлд Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг хүчингүй болгож 21.9.2 дахь хэсгийг мөн зүйлийн нэг дэх хэсэг болгон өөрчилж энэ хэсэгт “хууль сахиулагч”, “албан тушаалтан” гэх этгээдүүдийг эрүүгийн хариуцлага хүлээх этгээд болгон нэмж тусгана.

2. Эрүүгийн хуулийн 21.9.3-ийг 21.9.2 болгон өөрчлөөд “Мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг олж мэдсэн хүн баримт, мэдээллийг задруулж, нууцалсан гэрчийг илчилсэн”, мөн “шүүгч, прокурор, хууль сахиулагч, мөн мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг албаны үүргийн дагуу олж мэдсэн алба тушаалтан, алба хаагч, ажилтан тус мэдээллийг задруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол” гэх томъёоллыг хуульд ялган томъёолж тусгана. Ингэснээр “мөрдөн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээлэл” гэх өргөн хүрээтэй ойлголтын хүрээг хумьж зөвхөн “мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээллийг задруулсан этгээдэд нууцалсан гэрчийг илчилсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан гэх хоёр тусдаа объектод халдсанаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилна.
3. Энэ зүйлд заасан “нууцалсан баримт, мэдээлэл” гэх ойлголтыг эргэлзээгүй, тодорхой болгох, Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэх эрсдэлийг хаах үүднээс “мөрдөн шалгах ажиллагааны нууцалсан баримт, мэдээлэл” гэдэгт “зөвхөн шүүхэд хэргийг хэлэлцүүлэхээр танилцуулах ажиллагаа буюу шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээс өмнөх шатанд хууль сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нууцалсан гэрч, нууц мөрдөн шалгах ажиллагаа явуулж цуглуулсан нотлох баримтыг ойлгоно” гэсэн тайлбарыг хуульд нэмж тусгана.

Эрүүгийн хуульд дээрх нэмэлт, өөрчлөлтийг оруулсанаар Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь хэсгийг зөрчсөн байдал засагдаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй хүн, хуулийн этгээд, албаны бус бусад оролцогчдын хувьд тухайн хэргийн талаар өөрийн мэдэх хуулиар хориглоогүй баримт, мэдээллийн талаар олон нийтэд үзэл бодлоо илэрхийлж өөрийн эрх ашгаа хамгаалах, олон нийтийн мэдэх эрхийг хангах зэрэг эерэг үр дагавар нийгэмд авчирна. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал үр авчирдаг гэрчийг хамгаалах эрх зүйн орчин сайжирна.

Мөн энэхүү төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцсэн, Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Үндсэн хуулиар хамгаалсан иргэний эрх, эрх чөлөөг хэн нэгний үзэмж, хуулиар тогтоогоогүй субъектив хэмжүүрээр тодорхойлж халдах боломжгүй болгож байгаа нь тус хуулийн хууль зүйн үр дагавар болно.

Монгол Улсын Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсантай холбоотойгоор нийт 41 хуульд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулна.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн нэмэлт ачаалал үүсэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал өсөх зэрэг эдийн засгийн үр дагавар гарахгүй.